

G. M. Friters. Outer Mongolia and its international positions p. 236.

38. Монгол-Зөвлөлтийн харилцан туслалцах тухай аман хэлэлцээр (1934)

БНМАУ-ын Засгийн газрын төлөөлөгчид ЗХУ-д айлчлах үеэр 1934 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр «цэргийн довтолгооны занал аюулуудыг аль болох аргаар зайлуулахаар урьдаас сэргийлэх хэрэгт бие биедээ туслах ба мөн хэрэв Бүгд Найрамдах Монгол Ард Улс буюу Зөвлөлийн Засагт Нийгэм журамт Бүгд Найрамдах Холбоот Улсыг ямар нэгэн гуравдугаар этгээдээс довтолбол бие биедээ тусламж үзүүлнэ» гэсэн хүндэт ам хэлэлцээр байгуулжээ.

БНМАУ-ын гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхтгэл. I боть, 34 дэх тал.

39. Японы Гадаад яаманд Зөвлөлтийн элчин сайд Юренивийн гардуулсан мэдэгдэл (1935. VII. 6)

Монгол-Манжуурын хил дээр болж байгаа явдал болон Манжуур станцад хэлэлцээ явагдаж, тэдгээрт Квантуны армийн командлал идэвхтэй оролцож байгааг Зөвлөлт засгийн газар анхааралтай ажиглаж байна. Өөрийн хил хязгаарыг хамгаалах үүднээс Гадаад Монголын нутаг дэвсгэрийн халдашгүй байдлыг сонирхож байдаг Зөвлөлт засгийн газар, Япон-Манжийн цэргийн үйл ажиллагаа нь Япон-Зөвлөлтийн харилцааг хурцатгахад хүргэж болзошгүй гэж сэтгэл их түгшиж байна. Өнөөгийн Хэвийн тайван харилцааг хадгалахыг Зөвлөлтийн нэгэн адил сонирхож байдаг Японы Засгийн газар, Манж-Монголын хилийн тайван байдлыг хангах талаар Квантуны командлалд зохих заалт өгнө гэж Зөвлөлт засгийн газар итгэж байна.

Документы внешней политики СССР. Т. XVIII. с. 438—439.

40. Америкийн сонин сурвалжлагч Рой Говардын асуултад И.В.Сталины өгсөн хариултаас (1936. III. 1).

Рой Говардын асуултад Сталинаас хариулахдаа, хэрэв Японоос БНМАУ-ыг довтолохоор шийдвэрлэж, түүний тусгаар тогтносон бүрэн эрхт байдалд халдах аваас бид аргагүй туслах болно. «Японоос Уланбаатарыг эзлэн авахаар тавьж байгаа бодлого нь эцэстээ СССР улсыг шийдвэртэйгээр хөдлөхөд хүргэх үү?» гэж асуухад Сталинаас «Тийм ээ, хүргэнэ» гэжээ.

И. В. Сталин, Беседа с председателем американского газетного объединения «Скриппс-Говард ньюспейпер» г-ном Рой Говардом, 1937, с. 5

**Ховдыг чөлөөлсний 80
жилийн ойд**

**ХОВД ХОТЫГ ЧӨЛӨӨЛСӨН ТУХАЙ
ХОЁР БАРИМТ**

Хэрээд Л. Жамсран*

Цагаагчин гахай жил буюу 1911 оны 12 дугаар сард Их хүрээнд Халхын хүрээний бүх цэргийг түр ерөнхийлөн шийтгэх газар гэгч үндэсний эрх чөлөөний хувьсгалт эргэлтийг зохион байгуулах байгууллага байгуулагдаад олон монгол чуулган хошуудыг өөрсдийн нутагт суугаа Чин улсын жанжин, хэрэг шийтгэх сайд, түүнчлэн хуувийн сайд нарыг нэн даруй үлдэн зайлуулахыг зарлан тушаасан билээ. Хамгаас түрүүнд Их Хүрээний хэрэг шийтгэгч сайд Сань До амбан гэгч,

* Түүхийн ухааны дэд эрдэмтэн.

түшмэд, бараа бологчдынхоо хамт зайлан явсны дараа Их Хүрээнд Олноо өргөгдсөн Монгол улс байгуулсныг тунхаглаж, Ар Монголын шарын шашны тэргүүн VIII Жибзундамба хутагтыг шашин төрийг хослон баригч, наран гэрэлт, түмэн наст Богд хаан хэмээн өргөм жилж, Монгол улсын Засгийн газрыг таван яамны бүрэлдүүнтэй байгуулж, дотоод засгаа төвхнүүлэхийн зэрэгцээ монгол нутгаа Манж Хятадын ноёрхлоос чөлөөлөх үндэсний хувьсгалт тэмцэл өрнөхөд Улиастайн жанжин сайд түшмэдийнхээ хамт буун өгч, нутагтаа буцлаа. Харин Ховдын хуувийн сайд бууж өгөхгүй тулгар тогтсон Монгол улсыг зэвсэгт хүчээр эсэргүүцсэн тул олноо өргөгдсөн Монгол улсын төрд дагаар орж үндэсний нэгдмэл улсаа сэргээхийн төлөө хүчин зүтгэхээр ирсэн олон монгол угсаатны нэгдсэн зэвсэгт хүчин, төр шашны нэрт зүтгэлтэн, сайд нарын удирдлагаар хэдэн сар шаргуу тэмцэлдэн тулалдаж манж сайд, түшмэдийг хөөн зайлуулж Ховд хотыг чөлөөлснөөр монголын үндэсний эрх чөлөөний хувьсгалын Чин улсын ноёрхлоос ангижрахын төлөө тэмцлийн шат ялалтаар төгсөж, Ар Монголын нутаг бүрэн чөлөөлөгдсөн юм. Энэхүү түүхэн ялалтын 80 жилийн ой болж байгаатай холбогдуулан Ховдыг чөлөөлөх дайныг удирдсан сайд нарын айлтгал, Ховдын хуувийн сайдын өргөх бичиг зэрэг урьд нийтлэгдээгүй хоёр баримт бичгийн бүрэн эхийг ялихгүй тайлбартайгаар уншигч нартаа толилуулж байна. Эдгээр нь Ховдыг чөлөөлсөн түүхийг гуйвуулах гэсэн аливаа оролдлогод нэгэн мөрийн няцаалт болох буй заа.

Нэгдүгээр баримт бичиг

Шавь боол Дамдинсүрэн, Магсаржав, Наваанцэрэн, Дамдинбазар сөгдөж хичээнгүйлэн айлтгах нь:

Цагийг дагаж найртай төвшин болгох учраа удаа дараа ухуулсан хэрэгт огт аймшиггүйгээр зөрчилхийлж хотыг бэхэлж эсэргүүцэлдсэн Ховдын хотыг шууд цэргийн сүр хүчээр эвдэлж цэрэг иргэнийг хядан сөнөөсөн ба их төлөвийг айлган элсүүлж дагуулсан явдлыг зүй нь хичээнгүйлэн нугалбар бичиж айлтгаад Богд эзэн гэгээнээр айлдахыг гуйхын учир: Үүний урьд шавь боол Дамдинсүрэн¹, Магсаржав² нарын Ховдын хотыг эзлүүлэх учир ван Балдирын³ газраас гаргасан хүчирхэг цэргийг хядсан зэрэг хэргийн байдал дүрсийг тодорхойлон гаргаж нэгэнт айлтгасныг байцаавал: боолчуудын газраас Ховдын хотын манж сайд⁴, түшмэд, жич олон худалдааны иргэчүүдэд эрхгүй найртай ёсоор хэлэлцэж шийтгэе хэмээн хэд хэдэн удаа хугацаж ухуулах бичиг илгээсэнд тэдний манж хятад нар нэгэнт хэрэгсэхгүй. Харин хоршоо нийлж улмаар хорсол агуулж уул суусан хотын захын газрыг тойрон малтуулж, нуугдаж буудах орон засаж, бас ч монголчуудыг Хотын ойр үзэгдэх бүр буу тавьж эсэргүүцэлдэн байлдсаар боловч гагцхүү боолчууд зүйг эрж аргацаан шийтгэхийг хичээж Орос улсын консул сайдад хэлж найралдан тохиуулахыг манж хятад нарт ухуулан хэлэх ажаамуу хэмээн хэлсэнд,

Консул сайд даруй зөвшөөрч хоёр улсын хэргийг найртай болгон Хэлэлцье гэх учрыг урьдаар бичиг явуулаад дагалдаагаар консул сайд биеэр харьяат орос цэргүүдийг дагалдуулан авч манж сайд, түшмэдэд нүүр тулж уулзахаар очтол тэдний манж хятад нар консул сайдын өмнөөс буу тавьж хөөн зайлуулсан⁵ бөгөөд элдэвлэвч найралдан тохинож чадахгүйд хүрсэн заналтай байдал илэрхий мэдэгдсэн тул боолчууд бүгдээр зөвлөлдөж шууд дайлаар орохыг тогтож номун хан жал ханз хутагт Дамдинбазар⁶ тэрсүүд дайсны санааг номхтгож олон амьтныг амар жаргуулахын хутгийг гуйж дээд гурван эрдэнэд⁷ даатган залбирч олон лам нарын хамт ном уншиж, сайд зоригт бэйс Наваан-

цэрэнгийн⁸ хамт авч суусан ба Дамдинсүрэн Магсаржав нар оролдсон Тушаал сахилгыг хүндэтгэж олон аймаг хошуудаас хуралдсан бүх түшмэл цэргүүдийг яаравчлан жагсааж Их Монголын эрдэнэ бишрэлт засаг лам Дамбийжанцангийн⁹ хамтаар энэ он долоон сарын шинийн наймны үхэр цагт¹⁰ цэргийн хорооны газраас мордож мөн цагт Ховдын хотыг хүрээлэн дугуйрч, зоригт баатар тайж Тогтохын¹¹ Гэндэн, Найданжав, Насантогтох, Баргын Пунцаг, Сэргэлэн, Доржпалам, Гэлэггүнж нарын хамтаар боол Дамдинсүрэн¹² гагцаар огт аймшиггүй тугийг бариулан түрүүлэн орж буудалцсан ба Магсаржав¹³, Дамбийжанцан¹⁴, Мянбуу нар олон цэргүүдийг сайнаар дарангуйлан захиран тушааж, хашин хөөж тасалдуулахгүй залгалдуулан довтолгож явуулсаар, бэхэлсэн худалдааны хотыг эвдэж орж байлдуулан хядуулж сөнөөн дийлэхэд, тэдний манж хятад нарын хүчин санаа мөхөж, даруй тушаан ухуулсныг дагаж элсэн дагасугай хэмээн учрыг гаргаж дахин давтын гуйлгалан ирсэн тухайд дайралдахыг түр түдгэлзэж боолчууд Орос улсын консул сайдтан лугаа бүгдээр зөвлөлдөж, Ховдын хотны манж хятад нарын хадгалсан цэргийн зэр зэвсэг ба манж сайдын тамга нэг, тэмдэг зургааг хураан авч хадгалаад урьд бид нарын барин (олзлон—Л. Ж) авсан зэр зэвсэг, барьсан иргэчүүд нэг зуун гаруйг орос консул сайдтай зөвлөлдөж олон улсад хэлэлцэх хэргийн тэмдэг болгон хадгалж буй нь мөн цэрэгт орсон худалдааны иргэд зуугаадтай хамт харьяат хотны пүүсний иргэд дагахад бүгдийг (суллан—Л. Ж) тавив.

Манж сайд түшмэдийг орос консул сайдад буу тавьсны учирт хүлээлгэн буй. Консул сайдаар батлуулан бүгд явдлыг хэлэлцэж, тамга дарсан батлах бичиг авч нугалбарын дугуйд агуулж өргөхөөс гадна хоёр зуу гаруй цэргийг уналга хүнс өгч түшмэл цэргийг сонгон гаргаж харгалзуулан Нийслэл Хүрээнээ хүргүүлэхээс гадна эл байлдахад манай цэрэг талаас арван найман хүн алагджээ.

Боолчууд мэхийж хянавал үнэхээрийн түгшүүртэй цагт хорт санаа агуулж, хотыг бэхэлж харгислан халдахыг бодсон дайсан улсад аймшиггүй сүрийг бадруулан орж хядалцсан чин үнэнхүүгээс хүчин хавсарч тусалж дагалдан зүтгэсэн манай улсын бичиг цэргийн түшмэд жич, цэргүүд бас тулгар төрд санаа зутгаж сүслэн дагахын хамтаар хүчийг гүйцэтгэх цэрэг хүч үлэмжхэнийг туслан нийлүүлж биесээр захиран авч дагалдуулан хүрч ирсэн их бага түшмэд цөм сайшаалтай тул энэ удаа байлдсан хот болбол маш бэх батын дээр мөн сая дагаар орсон газар ба олон газрын бичиг цэргийн түшмэл, цэргийг энэ нэгэн удаа эрхгүй хуулиас ангид сайшаан хөхүүлэхийг үзүүлбэл улмаар дуурайн хөгжиж, баярлан зүтгэж хойч өдөр улс төрийг батлан хамгаалахад үнэхээрийн тустай болох болов уу хэмээнэ.

Иймийн тул сайшаан хөхүүлбэл зохигчдыг ялган салгаж урьд гуйсан зэрэг дэвийг жагсаан бичсэн нэрсийн хуудас наалдуулж хичээн гүйлэн нугалбар бичиж айлтгасан нь болох ба үл болох явдлыг Богдоор толилж, хишиг хүртээхийг гуйсугай.¹⁵ Бас гүн Хайсангийн¹⁶ бие цэргийн хамт хараахан ирээгүй. Хойд хязгаарыг сэргийлүүлж батлан тогтоох олон хэргийг бүгдээр боловсортол зөвлөлдөж өөр айлтгах явдлыг хамтаар сонгон айлтгав.

Зарлигийг гуймуй.

Олноо өргөгдсөний хоёрдугаар он,
долоон сарын арван таван.¹⁷

Монгол улсын Түүхийн төв архив.

ФА-4, х.н —3, 8-12 дахь тал,

Хоёрдугаар баримт бичиг

Урьд (ын) Ховдын хуувийн сайдаас¹⁸

олон түшмэл, цэрэг танаа тодорхой

учраа гарган өргөх учир:

Энэ жил хоёр¹⁹ сард худалдааны иргэд ба олон монгол хошуудаас Тагнын Урианхайн хүн нар Улаангомын зэрэг газрын худалдааны иргэдийн эд юм ба малыг булаан дээрэмдэж хүний амийг бусниулсан ба бас ч Ховдод ирнэ хэмээх үг буйг дараа дараагаар мэдүүлсэн тухайд, бүх зээлийн худалдааны иргэд, энэ мэдээг олж сонсоод зэрэг зэргээр хотод орж цэргийн зэвсэг тавин олгож хот зээлийг батлан сахиулму хэмээн гуйсан учир галт буу хоёр зууг, дарь хорголжийн хамт тавин олгож олны санаанд нийлүүлсэн. Санамсаргүй тэдний доторх ухваргүй худалдааны иргэд энэ бууг барьж гадагш гарч худалдаалах нь буй ажгуу. Хотын дотор үнэхээрийн мэдэхгүй дөрвөн сарын арван нэгнээ тус хотоос түшмэл цэргийг үлдэн хөөсөн Нядан Лхагва хоёр²⁰ хүнийг гянданд хорьж сахиулаад, хэрхэн шийтгэх явдлыг Бээжингийн Засгийн хэрэг шийтгэх газраа цахилгаан мэдээгээр лавлан өргөсний дараа Алтайн хэрэг шийтгэгч цзюнь ван Ба-гаас²¹ монгол зарлагын түшмэл Хөхийг гаргаж захиа ба бас Бээжингийн Засгийн хэрэг шийтгэх газрын хариу цахилгаан мэдээг бариулан илгээсэн нь таван сарын, хорин тавнаа Ховдод хүрч ирсэн учир Нядан Лхагваг буугаар буу даж алаад бас Улаангомоос зовлонгоос зайлан ирэгчдээс худалдааны иргэд бүх зээлээр жаран хүнийг элсэн хуруулж пүүсний баатар хэмээн нэрийдэн, бас нэг зуун хүнийг элсэж хотыг хамгаалах цэрэг болгоод цөмд дамнах буу ба галт буу, хорголж, дарь олгосон. Бас жалханз хутагт ба Орос улсын хэрэг барих түшмэлээс²² найрамдлаар хэлэлцсүгэй хэмээн илгээсэн албаны бичгийг хүлээн аваад, тус хотоос бас энэ учрыг гаргаж Хүрээ (Нийслэл Хүрээ—Л. Ж) лүгээ шийтгэмү хэмээн Бээжингийн Засгийн хэрэг шийтгэх газраа цахилгаан мэдээгээр нэвтрүүлсэн. Түүнээс хойно бас монгол жанжин сайдуудын бичиг захиа, хэд хэдэн удаа хүлээн авсан боловч цөм Бээжингийн Засгийн хэрэг шийтгэх газраас ёсоор болгосон цахилгаан мэдээг хүлээн аваагүй учир тус хотын газраас аймшиггүй өөрөө эзэрхэн чадсангүй.

Уулаас Монгол жанжин сайдууддаа энэхүү учраа тодорхойлон гаргаж хариу бичиг өгвөл зохих гагцхүү хариу цахилгаан мэдээг шууд хүлээсээр хариу бичиг эс өгсөн нь үнэхээрийн осол буруу болжээ. Дараа зургаан сарын арван нэгнээс эхлэн монгол цэрэг анги Ховдод хүрч ирсэн нь долоон сарын шинийн дөрвөнөө Орос улсын хэрэг барих түшмэлийг хүрч ирснийг мэдсэнгүй. Хотын цэрэг сэжиглэн буудсаны дараа нь мэдтүгэй хэмээн илгээсэн бичгийг хүлээн аваад осол буруу болсноо сая мэдэв. Шинийн долоонд зарсан түшмэл Худасан, жалханз хутагтын, түүний биеийг олныг амаржуулагч сүмийн газар очтугай хэмээн илгээсэн захиаг олж авсан боловч захиа хүрч ирсэнгүй. Дараа нь монгол цэрэг ирж хотын зүг байлдан ороход худалдааны зээлийн гурван этгээдэд цөм байлдах суваг, байлдах хашлага буй. Үүнд Алтай ба тус хотын цэрэг анги худалдааны баатруудыг жагсааж, хэрмийг тойрон батлан сахиж буу тавин эсэргүүцэлдэн байлдсан ба хотын дээрээс мөн ч буу, үхэр бууг бүхнээр тавин байлдсан нь хэдэн мөч хүрсэнгүйд монгол цэргүүд худалдааны зээлийг байлдан эвдсэнд тус хотын түшмэл, цэргүүдийг урьдаар их ерөнхийлөн захирах сайд Юань (Шикай-Л. Ж)-аа гашуунаар сахитугай хэмээсэн цааз, зарлагыг дагаж энэ газрын хүн иргэний амь бие, эд хөрөнгө энэ мэт зовлонд тохиолдсон нь цөм тэрхүү нэгэн хүний тул ташаарсан ба Ховд уулаас Халх хотоо суллан өгтүгэй хэмээн тушаасныг зөрчсөн нь үл зохилдохыг сая ухамсарлан мэдээд цагийг шүүмжлэн байдлыг хянаж, гэм-

шивчээр өгүүлж болохгүй чухамхүү түргэн түгшүүртэй бүхийн зуур жанжин сайдуудаас хүн зарж хотод оруулан найрамдлаар тараахыг дурлах эсэх. Хэрэв найрамдахад эс дурлавал энэ шөнө сааргүй хотыг эвдэнэ хэмээн хэлүүлсэн тухайд даруй түшмэл гаргаж хутагт ба жанжин сайдуудаас тэнгэр дэлхий мэт хишиг хүртээж, цэргийг зогсоож байлдааныг намхруулахыг гуйгаад басхүү Орос улсын хэрэг барих түшмэл Кү-гээс тус хотын осол бурууг уучлан, найртай сайныг санаж сайхнаар найрамдуулахыг гуйн тус хот тушаасныг дагаж цэргийн зэвсэг ба тамга тэмдэг, санхүү, албаны юмын зэрэг зүйлийг гаргаж тушаавай. Одоо хуувийн сайд ба олон түшмэл цэргүүд мөргөн гуйх нь тэмээ, морь, майхны зэрэг зүйлийг шагнан олгож мордуулан Уг нутагт буцаах ажаамуу.²³ Тодорхой учраа гарган өргөсөн нь үнэн. Үүний тул хичээнгүйлэн хуувийн сайд, занги, бичиг, цэргийн түшмэдийн нэрийг сүүлд жагсаан бичиж өргөв.²⁴

Дундад Иргэн Улсын тэргүүн он,
найман сарын хорин зургаан.
Монгол улсын түүхийн төв архив.
ФА-4, Х.Н. —3, 12—15 дахь тал.

Тайлбар

1. Жамсрангийн Дамдинсүрэн (1871—1921) бол Хөлөнбуйрын баргын сумын жинхэнэ занги бөгөөд 1911 онд Халхын Их Хүрээнд үндэсний эрх чөлөөний хувьсгалт эргэлт гарч, Олноо өргөгдсөн Монгол улсыг байгуулсны дараа, 1912 оны 1 дүгээр сарын 15-нд зэвсэгт бослого гаргаж, хүлэн хотоо чөлөөлөөд Олноо өргөгдсөн Монгол улстай нэгдэх шийдэр гаргасан баргын босогчдын даалгавраар уг бослогод Идэвхтэй оролцох зохион байгуулагчдын нэг. Шинэ баргын Шулуунцагаан хошууны гудгаар сумын занги Дамдинсүрэн баргын төлөөлөгчдийг тэргүүлж ирэхэд Монгол Улс талархан хүлээн авч, түүнд улсад туслагч гүнгийн зэрэг шагнаж Гадаад хэргийг бүгд захиран шийтгэгт яамны дэд сайдаар томилон ажиллуулсан юм. 1912 оны зун Ховдыг чөлөөлөх цэрэг яаралтай хөдөлгөх шаардлагатай болоход зарлигаар Ж. Дамдинсүрэнг С. Магсаржавын хамт баруун хязгаарыг төвшитгөн тогтоох сайдаар томилон явуулсан юм.
2. Сандагдоржийн Магсаржав (1877—1927) бол 1911 оны эхнээс Ховдын Халх жасаанд сууж байсан Сайн ноёны аймгийн түшмэл бөгөөд олноо өргөгдсөн Монгол улсыг тунхагласны дараа Ховдын байдал түгшүүртэй болж буй мэдээг Нийслэл хүрээнд нууцаар хүргэн ирж, Дотоод яамны дэс түшмэл болон дэвшээд. Дамдинсүрэнтэй хамт баруун хязгаарыг төвшитгөн тогтоох сайдаар томилогдсон юм.
3. Балдир гэгч бол Алтайн Шар сүмээс Ховдын хуувийн сайдад туслах хүч, зэвсэг ирүүлсэн ван ноён.
4. Манжийн тор Ховдын хязгаарын монголчуудыг чандлан захирахын тул 1761 онд «Зарлигаар зарсан Ховдод сууж хэрэг шийтгэх сайдын яам гэгчийг байгуулсан. Түүнийг толгойлж буй ноёныг хуувийн буюу зөвлөх сайд гэдэг. Өгүүлэн буй үед пүжүн (Бао Жүн) гэгч манж сайд байжээ.
5. 1912 оны 6 дугаар сард Орос улсаас Ховдод суух консулаар М. Н. Кузминский гэгч хүн томилогдон ирээд байжээ. Энэ явдал 1912 оны 7 дугаар сарын 4-нд болжээ.
6. Жалханз хутагт Дамдинбазар (1874—1923). Ар Монголын тамгатай 13 хутагтын нэг. Олноо өргөгдсөн Монгол улсыг байгуулж, шарын шашны тэргүүн Жибзундамба хутагтыг алхин төрийг хослон баригч хаанаар өргөмжилсөн үеэс улс төрийн амьдралд идэвхтэй оролцох болсон, 1912 оны зун зарлигаар Жалханз хутагт Дамдинбазар баруун хязгаарыг илбэн тохинуулах сайдаар томилогдон Ж. Дамдинсүрэн, С. Магсаржав, Р. Наваанцэрэн нарын хамт явсан. Дамдинбазар, түүний урьдах дүрүүд Баруун Монголд шашин шүтлэгийн талаар үлэмж нөлөөтэй байсан тул ийнхүү томилогдсон ажээ. Богд хаан түүний зүтгэлийг үнэлж «Самади багш», номун хан цол ба тамга шагнасан.
7. Багш, бурхан, ном гурвыг ийнхүү нэрлэдэг.
8. Монгол улсыг сэргээн байгуулахад үнэн санаагаар чармайн зүтгэсэн тул Засагт хан аймгийн гүнгийн зэрэг засаг, тэргүүн зэрэг тайж Наваанцэрэн (Агваанцэрэн ч гэдэг)-д Богд хааны хишиг тараах зарлигаар 1912 оны эхээр үе улиран хошууны бэйс, зоригт цол, хүрэн жолоо шагнаж Цэргийн яамны дэс түшмэлээр томоохон томилоод улмаар баруун хязгаарыг илбэн тохинуулах сайдаар томилон явуулсан юм. Ховдыг чөлөөлсний дараа түүнд зарлигаар жүн вангийн зэрэг олгож Ховдын хязгаарыг сэргийлэн батлах сайд болгосон.

9. Дамбийжанцан буюу Жа лам бол 1889 онд Улиастайд мөрний торгууд утсааны хүн, Тусгаар тогтносон Их Монгол улс байгуулах үзэл санааг түгээж, монгол, төвд орноор явж байгаад Баруун Монголд өөрийгөө Амар санаагийн хувилгаан гэж алдарцуулсан ажээ. 1912 оны хавар Ховдын хавьд ирж цэрэг элсүүлэн Монгол улсын цэрэг очиход угтаж нийлсэн байна.

10. 1912 оны 8 дугаар сарын 20-ны 02—04 даг.

11. Энхбилэгтийн Тогтох (1863—1922). Жирэмийн чуулганы Өмнөд Горлос хошууны тайж гаралтай хүн. XX зууны эхнээс Чин улсын ноёрхол, Хятадын колоничлогчдын эсрэг санаа нийлсэн нөхдийнхөө хамт тэмцэх болж, улмаар 1906—1910 онд зэвсэгт бослого удирдан, Хятадын колоничлогчидтой олон удаа тулалдаж, Эцэст нь давуу хүчинд шахагдан Халхын Сэцэн хан аймгийн нутагт орж ирээд Их Хурээний амбаны хөдөлгөсөн цэрэгтэй тулалдаад бас л давуу хүчинд шахагдаж, Орос улсын хязгаарт очиж хоргодож байгаад Их хүрээнд үндэсний эрх чөлөөний хувьсгал ялж, Олноо өргөгдсөн Монгол улсын хаан ширээнд Жибзундамба хутагтыг өргөмжлөх ёслолын өдөр хүрэлцэн ирээд төрийн ордонд бараалхан Богд хаанд мөргөх ёслол гүйцэтгэхэд түүнд тэргүүн зэрэг жинс, тогосын отго, зоригт баатар цол шагнаж шаргийн яамны дэс түшмэлээр тохоон томилж ажиллуулсан юм. Тэр 1912 оны зун баруун хязгаарыг төвшитгөхөд өөрийн харьяат дайчин нөхдөө удирдан явж, баатар зоригтой байлдан гавьяа байгуулсан тул Монгол улсаас түүнд түшээ гүнгийн зэрэг, зарим цэрэгт нь баатар цол, жинс зэргээр сайшаан шагнасан.

12. Т. Дамдинсүрэнд зарлигаар үе улиран залгамжлах засаг, төрийн бэйл, хоёр нүдний тогосын отго, цэргийн жанжин, Манлайбаатар цол шагнасан.

13. С. Магсаржавт зарлигаар үе улиран залгамжлах хошууны бэйс, хоёр нүдний тогосын отго, хатан баатар цол шагнасан.

14. Дамбийжанцан ламд ноён хутагтын хэргэм шагнаж, баруун хязгаарын олон монголчуудыг дагуулан тохинуулах сайд болгон дэвшүүлсэн.

15. Зарлигаар Мянбууд мэргэн баатар, Сэргэлэнд зетэй баатар, Пунцагт шаламгай баатар, Доржпаламд зоригт баатар, Гэлэггүнжид хавтай баатар гэх зэргээр гарамгай байлдаж гавьяа байгуулсан олон дарга цэргийг хөхүүлэн шагнасан байдаг.

16. Баянто мэрийн Хайсан (1857—1917). Зостын чуулганы Харчин баруун хошууны хүн. Хятадын колоничлогчдоос нутаг бэлчээрээ хамгаалах тэмцэсний улмаас хавчигдаж Харбин хотод ирээд Монголын сонин бичиг» гэдэг монгол сонины газар ажиллаж байгаад 1909 онд Их хүрээнд шилжин ирж Ханддорж жанжин, Цэрэнчимэд Да лам зэрэг Ар Монголын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний удирдагчидтай уулзаж хамтран ажиллах болоод улмаар 1911 оны зун тэдний хамт Орос улсад очиж тусламж эрэн Монгол улсыг сэргээн мандуулахад чухал үүрэг гүйцэтгэсэн учраас Олноо өргөгдсөн Монгол улсын Дотоод яамны дэс түшмэлээр томилогдсон бөгөөд жишиг тараах зарлигаар үе улиран чин зүтгэлт цол, улсад туслагч гүн, отго, хүрэн жолоогоор шагнагдсан. Тэрээр баруун хязгаарыг чөлөөлөх хэрэгт оролцож, баруун хязгаарыг төвшитгөн тогтоох сайдад зөвлөн туслах сайдаар томилогдон, цэрэг толгойлон очиж Ховдын албан сангийн мал хөрөнгийг хураан авах үүргийг сайн гүйцэтгэсэн учраас зарлигаар түшээ гүнгийн зэрэг шагнуулсан билээ.

17. Энэ бол 1912 оны 8 дугаар сарын 27-ны өдөр

18. Дээр дурдсан Пүжүн (Бао Жүн) гэгчийг хэлж байна. 19. 1912 оны 2 дугаар сар.

20. Монгол сурвалж бичгүүдэд Монгол улсын Засгийн газар торгууд гүн Төмөржин, халх түшмэл Лхагва нарыг томилон явуулсан гэж байдаг.

21. Балдир бололтой.

22. Оросын консул Кузминский.

23. Ховдыг чөлөөлөх тулалдааны үед Оросын консул, Монгол улсын цэргийн захиргаа ба манж амбангийн хооронд зуучилж байлаа. Иймээс Монгол цэргийн жанжин Дамдинсүрэн, Оросын консул Кузминский нар манж сайд (амбан) түшмэл, цэрэг, худалдаачдыг Оросын нутгаар дамжуулан нутагт нь буцаах, тэдэнд ачлага, унага, хүнснийлүүлахаас гадна хил хүртэл Монгол цэрэг хамгаалан хүргэх тухай протоколд 1912 оны 9 дүгээр сарын 2-нд гарын үсэг зурж Монгол улсын тал хүлээсэн үүргээ ёсоор гүйцэтгэсэн билээ.

24. Нэрсийн жагсаалтын эхэнд Ховдын хуувийн сайд, Улиастайн жанжинд дэвшсэн Пүжүн (Бао Жүн) -гээс эхлээд янз бүрийн зэрэг дэвийн хорь шахам хүний нэр бичигджээ.